



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2023 оны 09 сарын 21 өдөр

Дугаар 432

Улаанбаатар хот

Төрийн өмчит компанийн Төлөөлөн удирдах
зөвлөлийн гишүүдийг чөлөөлөх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 6 дахь хэсэг, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалт, Засгийн газрын 2023 оны “Цемент шохой” төрийн өмчит хувьцаат компанийн талаар авах арга хэмжээний тухай” 258 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.“Цемент шохой” төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлж буй гишүүн Ц.Баяр-Эрдэнэ /Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн дарга/, З.Энхболд /Хууль зүй, дотоод хэргийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газрын дарга/, Б.Доржсэмбэд /Сангийн яамны Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газрын дарга/, Б.Отгонцэцэг /Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн захиргаа, удирдлагын газрын Санхүүгийн хэлтсийн дарга/, Д.Гантулга /БХБЯ-ны Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга/, Г.Туул /Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Захиргаа, удирдлагын хэлтсийн ахлах мэргэжилтэн/, хараат бус гишүүн Д.Санчир, Б.Буянхишиг, Л.Ганбаатар нарыг Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээс 2023 оны 08 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон чөлөөлсүгэй.

2.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Ц.БАЯР-ЭРДЭНЭ